



0407

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 07

Мөрөн

**“Нийтийн ахуйн үйлчилгээний төв”
ХХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүдийг томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, 77 дугаар хуулийн 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийг төлөөлж оролцох гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ц.Мөнхтуяа- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч

Н.Шинэбаяр- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн хэлтсийн дарга

Р.Машбат-Аймгийн ИТХ-ын ажлын албаны хурал хариуцсан ажилтан

Ц.Эрдэнэбаатар-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн

Г.Төрбат- Тариалан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Б.Пүрэвдорж-Тариалан сумын Санхүүгийн албаны дарга

2. “Нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах хүмүүсийг томилсугай.

Г.Энхбаяр- “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал

П.Санлигрэнчин-Мөрөн сумын 6-р багийн иргэн

Г.Оюунбилэг-“Бат зол” ХХК-ийн менежер

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2017 оны 01 дүгээр сарын 20-ны дотор хуралдуулж, удирдамжийг батлуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д даалгасугай.

4.Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Цогтоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР